

**МОНГОЛЧУУДЫН БҮХЭЛ ШҮҮС ХӨНДӨХИЙН ЁС УЧИР ХИЙГЭЭД
“ХИШИГ ХҮРТЭЭХ” ЗАН ҮЙЛИЙН УЛАМЖЛАЛ**

Гэрэл*

(Товч агуулга)

Бүхэл шүүсний ёслолд зориулсан ерөөл магтаалд тонголчуудын найр хуримандаа хэзээнээс бүхэл шүүс тавих болсон. Бүхэл шүүс хөндөхийн ёс учир хийгээд бүхэл шүүсний бэлгэдлийн утга учир зэргийг бүрнээр тусгаж байдаг бөгөөд энэхүү бүхэд шүүс тавих ёсоо “Чингисийн хишгийн дээж” гэж онцлон үзэж байсан уламжлалт заншилын соёлын үндсийг шинжлэв.

(Түлхүүр үг) Ерөөл магтаал хишиг хүртээх соёлын үндэс

Эртний монголчууд тэнгэр тахихдаа хавар намрын тахилгыг их, зун өвлийн тахилгыг бага тахилга гэж нэрлэж, морь, хонь, үхэр гурваар тахидаг бөгөөд тахилгын өдөр алсан морь, үхэр, хонины махыг хурсан олон тэр өдөр үлдээлэлгүй идэж барах ёстой ажээ¹. Тахилгад дэвшүүлсэн өтөг шүүсээ тахилга гүйцэтгэгчид даяараа хуваалцан идэж орхидог нь балрын үеийн хүмүүсийн “хишиг хүртэх ёс” юм. Эртний хүмүүс тэнгэр газрын сахиусын адис хайртай тахилгын идээг хүртвэл хишиг нь нэмэгдэн батгаж, тэдний хайр энэрэлд ивээгдэнэ гэж ойлгодог байснаас тэнгэр газрын тахилгын зан үйлээр дамжин хишиг хүртдэг ёс нь тэдний хүсэл санааны бодот биелэл болж байжээ.

Монголчуудын өв тэгш их найр хуримын хамгийн хүндэтгэлт идээ нь болох шүүс тавих ёсонд шүүсийг болгохоос аваад шүүсийг таваглах, тавих, шүүсийг хөндөх, дэвшүүлэх зэрэг алхам нэг бүрт цөмдөө маш нарийн ёс дэглэмтэй байдаг бөгөөд хүндэтгэлийн бэлгэдэл санааны нарийн учир утгыг илэрхийлж байдаг. Энэхүү бэлгэдлийн нарийн учир утгыг хамгаас тодорхойгоор илтгэж чаддаг нь бүхэл шүүсний хүндэтгэлт ёслолд зориулан ерөөдөг ерөөл магтаал болох юм. Бүхэл шүүсний ёслолд зориулсан ерөөл магтаалд монголчууд найр хуримдаа хэзээгээс бүхэл шүүс тавих болсон, бүхэл шүүс хөндөхийн ёс учир хийгээд бүхэл шүүсний бэлгэдлийн учир утга зэргийг бүрнээр тусгаж байдаг гэж хэлж болно юм. Монголчууд өвтөгш их найр хуримдаа “бүхэл шүүс” тавьдгийн учир нь гийчин зочиндоо элбэг их мах идүүлэх гэсэн санаа огт биш, харин монгол хүний хүндэтгэлт бишрэлийн сэтгэлгээний үүднээс урган гарсан онцгой соёлын үзэгдэл болох юм². Монголчуудын аливаа хүндэтгэл ёсны идээ ундааны соёлд түүний идэх нь зорилго биш, харин түүнийг дээжлэх нь хамгаас чухал түрүүн зэргийн хүндэтгэлт ёслол болж журамжсан байдаг. Иймээс монголчууд хэзээдээ хүндэтгэлийн ёсны идээ ундаагаа “цайны дээж”, “сүүний дээж”, “сархадын

* БНХАУ, Баруун Хойтын Үндэстний их сургууль, профессор

¹ Ч. Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр гүн ухааны сэтгэлгээ. Хөх хот., 1992 он, 123-р тал

² Цэцэнмөнх. Ерөөл магтаал дахь монголчуудын соёлын сэтгэлгээ. Бээжин., 2000 он, 279-р тал

дээж”, “идээний дээж” гэхчилэн хэлдэг нь идээ ундааны дээжийг бэлгэшээн үздэг сэтгэлгээнийх нь бодотой тусгал болох юм. Тухайлбал “ Монголын идээн товчоо”-нд тэмдэглэсэн “бүхэл шүүсний ерөөл”-ийн эхний хэсгийг сийрүүлбэл:

“Богд Чингис хаан- иеэр
Бөртэгэлжин хатныг буулгаж авах тэр цагт
Бор халзан иргийн бүхэл-юүгээн
Болор тэвшинд тавагласнаас аваад
Эсгий туургат олон монголчууд Онон голын хөвөөнд
Есөн хөлт цагаан тугийг мандуулах тэр цагт
Ес ес наян нэгэн иргийн бүхэл-юүгээн
Яшил зандан тэвшинд тавагласан хүртэл
Чингис Богдын тогтсон журам
Чин зоригт монголчуудын заншил
Чигч үнэн сэтгэлийн минь бэлгэ
Цэвэр ариун идээний минь дээж
Алдарт түүхт монголчуудын заншил
Ам цагаан иргэний минь бүхэл
Арван улаан зүрхний минь бэлгэ
Амсан дээжлэх идээний минь дээж
Сүмэн өвс рашаан булгийн идээ ундаатай
Сүүн цагаан иргийн бүхэл-юүгээн
Садан төрөл ах дүү олон та нартаа
Сайны ерөөлөөр өргөн дэвшүүлж байна”³

гэхчилэн ерөөж байгаагаас үзэхэд ерөөлийн өөрийнх нь утга бол Чингис хаан Бөртэгэлжин хатнаа буулгах цагаас Онон мөрний хөвөөнд Их монгол улсыг ёслол байгуулсан цагаас энэхүү ариун тансаг ёс заншил гарсан хэмээн өгүүлж байна.

Мөн энэчилэн “Богд ноёдын хуримын хамаг бэлэг бүтээгч төлгөн хонины нүцгэн зум” хэмээх сурвалж бичгийн эхэнд тэмдэглэснийг үзвэл:

“Ариун тэнгэрийн орноо оршин бөгөөтөл
Амьтан бүхнээ жолоодон товчлохын тул
Алдаршсан замбуутивд мандаж
Арван зүгт зуун цол мянган алдраа түгээн гийсэн
Богд эзэн Чингис хааны зохион тавьсан
Хаад ноёдын хуримын хамгийн бэлгийг бүтээгч
Төлгөн хонины нүцгэн зумыг төгс бүхнээр
Авч ирсний тулд”⁴ гэж байх нь дээрх ерөөлийн өгүүлэмжтэйгээ нийлж

байгаагаас үзэхэд эсгий туургатны хамаг бэлгийг бүтээгч зум хуримын есөн ёсыг Чингис хаан монгол төрийн эзэн болж, есөн хөлт цагаан тугаа мандуулж, Онон мөрний хөвөөнд Их монгол улс байгуулагдсан өвтэгш ёслолоо үйлдсэн тэр цагаас төр ёсны өвтэгш найр хуримын тэргүүн бэлгэ болгон тогтоосон байж болох юм. Ерөөлийн өгүүлэмжид тухайн өвтэгш их найр хуримын ёслолдоо зориулан “ес ес наян нэг иргийн бүхэл-юүгээн, яшил зандан тэвшинд тавагласан” гэж байдаг нь түүхэн үнэнтэй нийцэж байгаа бололтой. Учир нь тухайн үеэд Чингис хаан тэнгэрлэг есийн тоогоор төрт ёсны хүндэтгэлийн бэлгэдэл тоогоо болгосон байдаг.

³) Бүрэнтөгс. Монголын идээн товчоо. Улаан хад., 1987 он, 39-р тал

⁴) Алтан- Оргил. Эсгийн туургатны хамаг бэлгийг бүтээгч зум хуримын есөн ёс. Өвөрмонголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн., 1986 оны 2-р хугацаа

“Бүхэл шүүсний ерөөл”-ийг цаашид нягтлаж үзэх тутам улам сонирхолтой болох бөгөөд ерөөлийн дотор бүхэл шүүсний хаанаас эхэлж яаж хөндөхийг ч нарийн өгүүлж байдаг:

“Болор эрдэнэ толгойг нь магнайлан хөндөж
Мөч дөрвөн хөлийг нь хартиулан хөндөж
Наран талаар нь эргүүлж нарийн сайхан хашиж
Өлзий талаар нь эргүүлж үе үеэр салгаж
Үе үеэр салгаж
Өвгөдийн ёсоор хөндөж
Мөч мөчөөр салгаж
Монголын ёсоор хөндөж”⁵ гэж ёсчлон зааж байдаг.

Бүхэл шүүсний толгойг магнайлан хөндөх гэдэг нь “баярын магнай” хэмээн хонины толгойн магнай дунд тонолжин (+) тэмдэг буюу хас () тэмдэгийн дүрсийг дууриалган эсгэж, ууцны голд хүндэт гийчин рүү хошууг хандуулан тавихыг хэлж буй. Өвөр монголын Хэшигтэн зэрэг газарт толгойд нь мөнгөн хас тамга өлгөдөг ёс ч бий. Бүхэл шүүсийг магнайлан хөндөх ёс нь их эртний засуулын ёс гэдгийг “Чингис хааны тахилын судар оршвой” гэх зэрэг түүхэн сурвалж бичгүүдээс ойлгож болдог бөгөөд энэ нь мөн ч хамаг бэлгийг бүтээгч зум хуримын есөн ёсны түрүүн зэргийн хүндэтгэлийн ёс болдог гэдгийг “Богд ноёдын хуримын хамаг бэлгийг бүтээгч төлгөн хонины зум” хэмээх бичигт “анхны ёс төлгийн магнайг нь эсгэж, өргөхийн дүрийг үзүүл” гэж байхаас тодорхой мэдэж болно. Дээр үеийн бүхэл шүүсний засуулын ёсонд хонины толгойн магнайн дунд тонолжин тэмдэг эсгэж төрийн хаад ноёдод шүүсний дээж хэмээн барьдаг байсан бол сүүлийн үед энэхүү засуулын ёсонд хувирал гарч хонины толгойн магнайд нар сарыг эсгээд ууцны сүүлээс нь нимгэн халимлан авч толгойн дээр нь тавьж гэрийн эзэнд барихад гэрийн эзэн нь бурхандаа дээж болгодог байна. Энэ нь мөн бүхэл шүүс тавих ёсыг нь уулдаа (угтаа) төрийн хаад ноёдын найр хуримын хүндэтгэлийн ёсонд зориулж байсан бол аажимдаа ард иргэдийн найр хуримын хүндэтгэлийн засуулын ёс болсон гэдгийг гэрчилж байна. Бүхэл шүүсний хонины толгойг ийнхүү онцлон үзэж, магнай дээр нь тонолжин буюу хас тэмдэг эсгэж байдаг нь нэг талаар сүнсний шүтлэгийн ухамсартай холбогдохын зэрэгцээ нөгөө талаар бүхэл шүүсний бэлгэдэлийн учир утгаа дохио тэмдгийн аргаар илэрхийлж байгаа нь тодорхой байна. Тонолжин тэмдэг буюу хас тэмдэг нь их эртний хүмүүсийн оюун санаанд сүсэг бишрэлийн бэлгэдэл тэмдэг болж байжээ. Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд энэхүү хоёр зүйлийн тэмдэг нь нэг нь нөгөөгөөсөө улиран хувьсч, адил бус улс гүрэн, үндэстэн угсааны шүтээн тэмдэг болж иржээ. Тонолжин тэмдгийн бэлгэдэл маш баялаг, тэр нь дөрвийн тоо буюу тэгш дөрвөлжиний бэлгэдлийн санааг агуулж байдгаас газар дэлхий буюу ертөнцийн зүг чигийн илэрхийлэл болдгийн зэрэгцээ амь амилалын хүчний бэлгэ тэмдэг болж байдаг. Хас тэмдэг ч бас зөв эргэсэн хас, буруу эргэсэн хас гэж байдаг бөгөөд тэр нь тэнгэр газрын төлөөл болж байдаг. Зөв эргэсэн хас нь тэнгэрийг төлөөлж, тэнгэрлэг утгыг илэрхийлдэг. Монголчууд хас тэмдгийг түмэн өлзийгийн бэлгэдэл гэж үздэгээс бүхэл шүүсний хонины толгойд тонолжин буюу хас тэмдэг эсгээд түүнээ “баярын магнай” гэдэг нь “түмэн өлзий төгс жаргалантай” байхын бэлгэдэл санааны учир утгыг илэрхийлж байх юм. Зарим нутгийн заншилд бүхэл шүүсний хонины толгойн магнайд нар сар сийлдэг ёс нь дээрх бэлгэдэл санааных нь тодорхой илэрхийлэл болно.

Мөн дээрх ерөөлийн өгүүлэмжид “дөрвөн мөчийн хөлийг нь хартилан хөндөж, наран талаар эргүүлж, нарийн сайхан хашиж” гэж байх нь бүхэл шүүсний толгойг эхэлж хөндсний дараагаар бүхэл шүүсээ зүсэх ёсыг хэлж байна. “Хонины маханд

⁵) Бүрэнтөгс, Монголын идээн товчоо, Улаан хад 1987 он, 87-р тал

хойно өмнөтэй, хоноцын хүнд хол ойртой” гэдэгчлэн шүүсийг хаанаас нь эхэлж хаашаа зүсэх нь маш нарийн журамтай байдгаас зүсэлтийн ёс нь хүндлэхийн хэмжээг заана гэсэн үг. Дээр үед зум хуримын хүндэтгэлийн ёсонд есөн ёс гэж байжээ. Гэхдээ энэхүү ёс нь монголын овог ястны дунд одоогоороо уламжлагдаж байх нь цөөхөн болсон бөгөөд нэн цаашид мартагдах хэмжээнд хүрчээ. Бүхэл шүүсийг эвдэхэд заавал баруун талын хаагаас эхэлнэ нар зөв эргүүлж баруун хаа, зүүн гуя, зүүн хаа, баруун гуя гэх мэтчилэн зөрүү өрөөлдөн мөчлөхийг анхаарах бөгөөд ууцаа зүсэхдээ ч зөв талын сүвээний сүүлийн хажуугийн хэсгээс харцаганы хоёр зураа дагуу өөд нь хуруу өргөн зүсэж, сүвээний хавирга тулгасны дараа сүвний хавиргын үзүүр тийш хөндлөн зүсэж сэтлэнэ. Дахин буруу талын сүвний хавирганы доогуур гаднаас дотогш хөндлөн нэг зүсэж, дараа нь тэрхүү хөндлөн зүслэгээсээ хуруу өргөн гулдаар ас(яг) доош нь сүүлийн үзүүрийг туулан зүснэ. Энэ мэтээр зөв буруу хоёр талын сүвээнээс тус бүр хоёр зүсэм зүсээд ууцны гол дунд нь баруун зүүн дэс дараагаар зөрүүлэн (# хэлбэртэй) солбиж тавьдаг. Энэ нь даруй ерөөлд дурьдсанчилан “наран талаар эргүүлж нарийн сайхан хаших” ёсон билээ. Энэ нь мөн ч нарын зөв эргэлтийн бэлгэдэл утгатай холбогдохын зэрэгцээ ертөнцийн тоон “дөрвөн” бэлгэдэл утгатай ч холбогдож, аливаа бүхний санаачлан бүтэхийн бэлгэдэл болж байдаг. Хэдийгээр монгол угсаатны ууц зүсэх ёс нь тус бүртээ өөр өөр гэдэг боловч нар зөв эргүүлэн зүсэх ёс нь нийтлэг заншил юм. Эртний зум хуримын шүүс хөндөх ёсонд “есөн ёс” байсан бөгөөд тэр нь эртний тэнгэр газрын тахилгын ёсноос улирч ирсэн бололтой. Тухайлбал, Хэшигтэн зэрэг газарт шүүс эвдэгч нь нэн түрүүнд толгойн дух, хоёр завж, хоёр чих, хоёр ухархай, шил, тагнайгаас есөн хэсэг авч тэнгэр газар өргөдөг⁶ нь эртний тахилгын ёсны үлдэгдэл ёс болох юм. Энэхүү тахилгын сацал өргөх ёс нь хаад ноёдын зум хуримын ёстой арай өөр болсон бололтой. Лувсанчойдон “Монголын зан аалийн ойлбор”-доо бүхэл шүүс өгдөг ёсны тухай тэмдэглэхдээ: “Махны хэсгийг зүсэхэд нимгэн, зузаан, их багын адил тэгш дантай (хэмжээтэй) зүсэж, есөн хэсэг чацуу даалгаж чадах хүн нь бүхэл унагаж чадах нэртэй хүн болмой. Энэ бүхлийг хэсэглэх ёс нь болбоос: нэг хэсгийн тэнгэрт өргөмөй, хоёр хэсгийн газарт сацмой, гурван хэсгийг бурхандаа асгамой, дөрвөн хэсгийн чөтгөрт өгмөй, таван хэсгийг хүнд барьмой, зургаан хэсгийн уул шансид орхимой, долоон хэсгээр хүүр онгоныг тахимой, найман хэсгийн хувь болгож газар усны эздийг тахимой, есөн хэсгийг хаан эзэнд өргөмөй” гэв⁷. Үүний зум хуримын есөн ёсны уламжлалт заншил гэж хэлж болох юм. Гэхдээ эртний хаад ноёдын зум хуримын есөн ёс нь дээрх ёстойгоо арай өөр байсан гэдгийг “Богд ноёдын хуримын хамаг бэлгийг бүтээгч төлгөн хонины нүцгэн зум” гэдэг сурвалж бичгээс тодорхой ойлгож болох юм.

Энэхүү есөн ёсны сүүлийн гурван ёсыг тус бичигт: “долдугаар ёс, зүүн сүвээ нуруу, сүүл, бүхэл биеийн дээжийг авч ес сац. Богд ноёдын хуримын хамаг бэлгийг бүтээгч төлгөн хонины нүцгэн зумын; наймдугаар ёс, төгрөг их түмлий гучин дөрвөн үе, хорин дөрвөн нуруу, хорин найман мөч, арван зургаан яамын тэргүүнтнийг дээжлэн авч ес ес сац. Хаад ноёдын хуримын хамаг бэлгийг бүтээгч төлгөн хонины нүцгэн зумын; ес дүгээр ёс эрхэм бэлгэт сайн үгсээр ерөөж базаахын дүрийг үзүүл.”⁸ гэж тэмдэглэж байдаг. Үүнээс үзэхэд эсгий туургатны хамаг бэлгийг бүтээгч зум хуримын есөн ёс нь одоогийн уламжлалт ёстойгоо арай өөр байсан бөгөөд энэхүү ёс ес нь уулдаа төрийн эзэн хаадад зориулагдаж байсан гэдэг нь тодорхой болдог байна. Өөрөөр хэлбэл, монгол домог зүйн есийн тоогоор бэлгэдэн тэнгэр язгуурт хаан төрийн их ёслол, хурим

⁶) Бүрэнтөгс, Монголын идээн товчоо, Улаан хад., 1987 он, 125-р тал

⁷) Лувсан-Чойдон “Монголын зан аалийн ойлбор”, Хөх хот 1981 он, 61-р тал

⁸) Алтан-Оргил. Эсгийн туургатны хамаг бэлгийг бүтээгч зум хуримын есөн ёс. Өвөрмонголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн., 1986 оны 2-р хугацаа

найрын хүндэтгэлийн идээ гэдгээ илэрхийлдэг байжээ. Энэ нь домог зүйн ерэн есөн тэнгэр, тэнгэртээ өргөдөг есөн сацал, тэнгэрлэг есөн хүсэл, есөн эрдэнэ, тэнгэр гаралт эзэндээ өргөдөг есөн цагааны бэлэг гэх зэрэг эрхэмсэг дээдийн есөн тооны бэлгэдэлт утгын илэрхийлэл болж байдаг.

Эртний монголчуудын бүхэл шүүс хөндөх ёс нь иймэрхүү нарийн бэлгэдлийн учир утгыг илэрхийлдэг байсан бол зоогийн шүүсний хишиг хүртээх ёс нэн нарийн журамтай байсан гэдгийг “бүхэл шүүсний ерөөл”-ийн өгүүлэмжээс ойлгож болно. Жишээлбэл:

“Үе бүхэн нугалаатай
Нугалгаа бүхэн хишигтэй
Өвгөд настанд дээжтэй
Өсвөр хүүхдэд хувьтай
Эрдэнэ түрүүн уураг сүүлий нь
Өвгөд ихэстэй дэвшүүлж
Өвчүү, туух, сүүжий нь
Эрхэм зочдодоо дээжлүүлж
Дал дөрвөн өндрий нь
Дотно төрөлдөө барьж
Дараа дэсийн ёсоор
Даяар олондоо амсуулж
Хуучин журмыг барин
Хувь тэгш амсуулна
Анхны журмыг ёсчлон

Алаг ялгаагүй амсуулна”⁹⁾ гэхчлэн ерөөж байхаас үзэхэд бүхэл шүүсний мөч болгонд хүндэтгэлийн нарийн дэг журамтай байдаг гэснийг ойлгож болох юм. Монгол ардын ярианд “хариу хүнд харти”, “боломжгүй хүнд богтос”, “нагацын дал, зээгийн сүвээ”, “ууцыг дал дагадаг, уулыг мод дагадаг”, “дал дөрвөн өндөр дагавартай”, “тайжийн ууц таван нуруутай, харцын ууц гурван нуруутай” гэх мэтээр хэлэлцдэг нь энэхүү нарийн ёс журмын илэрхийлэл болох юм. Бүхэл шүүсний зоогийн энэхүү нарийн журам нь овог төрлийн байгуулалын үеийн дээдсийн тахилгын хишиг хүртэх ёстой холбогдон гарсан заншил байж болох юм. Эхэс дээдсийн тайлга тахилгын ёсонд дээдсийн хайр адистай хишгийг хувааж олох нь өөрийн овгийн дээдсийн хайр хишигт ивээгдэж байна гэсэн үг юм. Тиймээс овог төрлийн байгуулалын үеэд дээдсийн тахилгын хишиг хүртэх ёсоор дамжин тухайн овгийн гишүүдийн харьцаа холбоо, байр суурийг бэхжүүлдэг байжээ. Тухайн энэхүү хишиг хүртээх ёсонд овгийн гишүүдийн байр суурийг нь үндэслэж ямар зэргийн байр суурьтай гишүүнд шүүсний аль нэгэн мөч эрхтнийг олгоно гэдэг нь нэгэнт тогтсон нарийн журамлалтай байсан тухайд Алтан ордны тайлгын хишиг хүртээх ёсыг үндэслэвэл тахьсан жононд морин өггийн гуравциг ба хонины гуравциг шаант чөмгийг өгдөг бусдыг нь дархадын яамтад нар аль яам бол өөрсдийн авдаг хувь хувиа авдаг байна. Жишээлбэл одоогийн хороо нэгдлийн Шухайн сүм бригадад байгаа манлайн хэсгийн яамтан арлуд ястай Хэрэйд овогтон дунд чөмөг хувааж олдог байна. Шивэртэй шухуй хоёр бригадаар байгаа хэрэйд овогтой баругуд ястай “зарим нь боржигон ястан гэв”. Усван хишгийн яамтад бол сүүж авдаг байна¹⁰⁾. “Шар дархадын яамтад ихэсийн тайлгын хишиг хувааж авдаг нь тусгай тайлгын хууль бичсэн судрын зарлигийг үндэслэж гэнэ”¹¹⁾ үүнээс үзэхэд ихэсийн тайлгын тахилгын ёсонд ямар зэргийн байр суурьтай гишүүнд шүүсний аль нэгэн мөч эрхтэнг олгоно

⁹⁾ Бүрэнтөгс, Монголын идээн товчоо. Улаан хад., 1987 он, 131-р тал

¹⁰⁾ Сайнжаргал, Шаралдай. Алтан ордны тайлга. Бээжин., 1983 он, 56-р тал

¹¹⁾ Сайнжаргал, Шаралдай. Алтан ордны тайлга. Бээжин., 1983 он, 69-р тал

гэдэг нь нэгэнт тогтсон нарийн дэглэмтэй юм. Энэхүү хишиг хүртээх нарийн дэглэм ёс нь монголчуудын шүүсний зоогийн хүндэтгэл ёсны нарийн дэг журам болон хэвшин тогтворжсон байна. Энэ тухайд монголын хуучин уламжлалт хүндэтгэлийн зоогийн ёсны зан үйлээс жишээ авч үзэхэд халх нутагт “битүүний орой ёслолын хоол харилцан өгөхөө “битүүлэг зөрүүлэх” хэмээн нэрлэх бөгөөд битүүлэг зөрүүлгэний дээж түрүү маханд эрэгтэй хүнд голдуу дал дөрвөн өндөр, бас тэвхэн ууц, гэрийн эзэгтэйд сүүж, цагаан мах, өвчүү, хүүхдийн хувь маханд үмхэлцэг, шаант, богц чөмгийг хавирга махтай хоршиж өгдөг ажээ”¹². Үүнээс гадна битүүний орой хонины бүтэн мах тавагт тавихад гэрийн эзэн эхэлж есөн хөндлөн толгой хошуу хоёр эрүү хоёр чих ууцны талыг хөндөж галдаа өргөдөг. Дараа нь бурхандаа өргөөд гэрт байгаа хүмүүст хувь тархааж өгдөг. Гийчид “эр хүн” ирэхэд ууц чанаж өгдөг. Тэр зочин ууцны хоёр талаас өөлж галд өргөөд толгойг эзний зүг харуулж өгөөд эзэн хөндсөний дараа бага сага иддэг. Зочныг явахад толгой ууцыг хонго, тойг, шаант, дөрвөн өндөртэй нь дагуулан түүнд өгч ганзгалуулаад явуулдаг. Эмэгтэй зочинд хэрвээ залуу бол сүүж, хонго, хавирга, хаа, гуяа чанаж өгдөг. Настай хүнд толгой ууц өвчүү чанаж хүндэлнэ. Тэр хүн толгойг гэрийн эзнээр эхлээд хөндүүлж дараа нь өөрөө авч дээжийг нь галд өргөөд иддэг байна. Гэр тусгайлан гарсан хөвгүүд охид аав ээждээ золгохоор ирэхдээ заавал ууцтай ирж золгодог. Хүүхдийн угаалгын үеэд хонь төхөөрч, эх барьчид ууц бусад дагуул махтай хүүхдийн эхэд дунд чөмөг, хүүхдэд уураг сүүл, хүндэттэй зочинд дал дөрвөн өндөр, хавирга ноогддог байжээ. Хурим найрын үеэд ёслол хүндэтгэлийн махан зоогийг хуваахдаа эрэгтэйчүүдийг хонины толгой цээжин талын махаар, эмэгтэйчүүдийг ууц хонины бөгсөн талын махаар зочилох уламжлал бас бий.

Өвчүү бол эмэгтэй хүн буюу зээдээ өгдөг мах ажээ. Зээ нагацынхаа дэргэд дал барьдаггүй, нагац нь тэднийхээ дэргэд өвчүүнд хүрэх учиргүй ажээ. Халимаг монголд хамгийн хүндэттэй зоог нь хонины толгой юм. Чанасан толгойн доод эрүүг урьдчилан залгаж гэрийн хамгийн ахмад настай буюу хүндэт зочинд барихдаа хүшууг нь түүн зүү хандуулж өгдөг. Толгойн дараа хамгийн хүндэттэйд дал ордог бөгөөд ахмад настай буюу хүндэт зочин, эрэгтэйчүүдэд өгнө. Хижээл насны эрэгтэйчүүдэд шаант болон богтос чөмөг (атгаал чөмөг) ууц харин ахимаг насны эмэгтэйчүүдэд дунд чөмөг, бүсгүйчүүлд өвчүү, хөвгүүдэд бөөр чих, охидод зүрхийг хоёр хувааж өгдөг¹³. Зоогийн ёсонд насны ялгал чанарын ялгал бйар суурийн ялгал зэргээс шалтгаалагдаж оногдох хувь нь ч дор дороо адил үгүй нарийн журамтай байдаг гэсэн тодорхой юм. Энэ бүхнээс үзэхэд толгой дал ууц дөрвөн өндөр шаант чөмөг зэргийн хүндэтгэлийн маханд ордгийн учир нь дээр үеэд овгийн ахлагч төрлийн дээдэст зориулагдаж байсантай холбоотой гэлтэй. Юу гэвэл, эдгээр хамгийн хүндтэй мах гэснээ голдуу ахмад эрэгтэй хүнд өгч буй нь эцгийн эрхт ёсны нөлөөгөөр тайлбарлагдах боловч овог төрлийн байгууллын үеийн дээдсийн тахилгын ёсонд эдгээр хүндтэй мах нь овгийн ахлагч төрлийн дээдсийн хишигт оногдох байснаас зоогийн ёсонд онцгой хүндтэй мах болж онцлогдох болсон байлтай. Тухайлбал, “эцгийн дэргэд толгойн мах барьдаггүй”, “нацагийн дэргэд дал барьдаггүй”, “далыг даяараа” гэх мэтийн тусгай цээрлэл ёс байхаас гадна ерөөлийн үгэнд ч “Богд эзэнд зоог болсноор борви шагай чөмөг гуравдугаар гэнэ”¹⁴ гэж гарч байдаг нь энэхүү ёс заншилын ул мөрийг тайлбарлах баримт болж байна. Ингээд хэлэхэд “бүхэл шүүсний ерөөлд дурьдсанчилан “нугалаа бүхэн хишигтэй” гэдэг нь зоогийн ёсны энэхүү нарийн журмаа зааж хэлсэн нь тодорхой болдог.

¹²⁾ Бүгд найрамдах монгол ард улсын угсаатны зүй. Хөх хот., 1992 он, 211-р тал

¹³⁾ Х. Сампилдэндэв. Малчин ардын зан үйлийн уламжлал. Улаан хад., 1989, 29-р тал

¹⁴⁾ Хасбилэгт, Ордосын хурим, Хөх хот., 1984 он, 36-р тал

Хураангуйлбал, эртний монголчуудын бүхэл шүүсний зоогийн энэхүү нарийн журам нь овог төрлийн байгууллын үеийн дээдсийн тахилгын хишиг хүртэх ёстой холбогдон гарсан заншил байж болох юм. Энэхүү хишиг хүртээх ёсонд овгийн гишүүдийн байр суурийг үндэслэж ямар зэргийн байр суурьтай гишүүнд шүүсний аль нэгэн мөч эрхтэнг олгоно гэдэг нь нэгэнт тогтсон нарийн журамлалтай байсан гэдгийг түүхэн сурвалжаас ойлгож болно.

SUMMARY

The author discusses the ancient ritual tradition of sharing meat and the Mongolians' custom of meat cutting which holds symbolic meaning as analyzed from '*Chingis-un hishigyn deej*'. Since early times, Mongolians have had a unique ritual tradition and custom of sharing meat depending on ranks in a tribe. Also there are special rules regarding which bones should be eaten by whom.